

“Авлигагүй нийгэм-тогтвортой хөгжлийн гарц”
сэдэвт Үндэсний бага хурал дээр Авлигатай
тэмцэх газрын дарга Б.Дангаасүрэнгийн
тавьсан илтгэл

Авлигатай тэмцэх газраас баримтлах бодлого, чиглэл

Үндэсний бага хуралд оролцогч эрхэм нөхөд өө!

“Авлигагүй нийгэм - тогтвортой хөгжлийн гарц” сэдэвт Үндэсний бага хуралд онцгой ач холбогдол өгч өөрийн ивээл дор зохион байгуулж байгаа Монгол Улсын Ерөнхийлөгч танд юуны урьд талархал илэрхийлье.

Монгол Улсын төр, засгийн өндөр албан тушаалтнууд энд хуран цугларч сүүлийн арав гаруйхан жилд Монгол орныг “аалзны тор шиг” хэрсэн авлигатай тэмцэхэд хүч хэрэгслээ нэгтгэхээ илэрхийлж буй энэ мөчид та нөхөдтэй санал бодлоо хуваалцаж, цаашдаа нягт хамтран ажиллах бололмж тохиож байгаад баяртай байна.

Монгол Улсын хөгжлийг түргэтгэх нэг гол хөшүүрэг авлигатай тэмцэх явдал гэж үзсэн эрүүл саруул сэтгэлгээ, шударга үйл хэргийг тууштай дэмжиж төрийн хууль тогтоогчид 2006 оны 6 дугаар сард Авлигын эсрэг хуулийг баталснаар мөн оны 11 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болж, 2007 оноос хараат бус бие даасан Авлигатай тэмцэх газар байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

Авлигатай тэмцэх газар бүрэн утгаараа ажиллах хууль эрх зүйн орчин, санхүүжилт, орон байрны асуудал хараахан бүрдээгүй ч бид түүнийг хүлээж гар хумхиж зүгээр суусангүй.

Бусдын нөлөөнд автахааргүй, шударга хийгээд чадварлаг ажилтнуудыг шалгаруулан сонгон авч тэднийг гадаад, дотоодын сургалтад хамруулах, байгууллагын албан хаагчдын ёс зүйн, сахилгын, дотоод албаны зэрэг олон тооны дүрэм, журам боловсруулан баталж мөрдөж байна. Шинээр гал голомтоо асааж буй айлд хэрэг болдог бүхнийг олж авах, барилгын засварын төсөв хийлгэж засгийн газраар

батлуулж уг ажлыг эхлүүлж, одоо төсвийн тодотгол хийж Улсын Их Хурлаар батлуулахаар хөөцөлдөж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигын түвшин, цар хүрээ, хандлагыг судалж авлигын индекс, төрийн үйлчилгээг үзүүлдэг байгууллагуудын шударга байдлын үнэлгээ гаргах зэрэг судалгааны ажил хийхэд шаардлагатай хөрөнгийн төсөв, төлөвлөгөө боловсруулан манай улсад төсөл хэрэгжүүлэгч олон улсын байгууллагуудад хандаж, тэдэнтэй хамтран ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газраас авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг зөв гаргуулах, албан хаагчдыг шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, сургалт, семинар зохион байгуулахад НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар, Дэлхийн банк, Азийн сан ихээхэн дэмжлэг, туслалцаа үзүүлж байгаад талархал илэрхийлж байна.

Улсын Их Хурлаас Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах авлигын хэргийн харьяалал тогтоож өгөөгүй, тийм эрхийг олгоогүй байгаа нь Авлигатай тэмцэх газар ажил хийхгүй байна гэсэн ойлголтонд хүргэж, олон нийтийн хүлээлтийг улам бүр ихэсгэж байна

Түүнчлэн төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, дүн шинжилгээ хийх тухай журам, гарын авлага боловсруулж, энэ ажлыг гардан хэрэгжүүлэх ажилтнуудад сургалт-семинар зохион байгуулав.

Төрийн албан тушаалтны ил тод, шударга байдлын нотолгоо болох хөрөнгө, орлогын мэдүүлгээ цаг тухайд нь үнэн зөв гаргах талаар сургалт семинар явуулж, гарын авлага материалаар хангаж, зохих зөвлөгөөг өгч ажиллаж ирэв. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч нарыг мэдээллээр хангах ажлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хичээл сургалтын хэлбэрээр явуулж, төв орон нутгийн 30-аад байгууллагад очиж ажиллав. Өнөөдрийн байдлаар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчдын тоо 47500 орчим, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан 1200 байна. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үйл ажиллагаа улсын хэмжээнд 20 гаруй хувьтай байгаагийн дотор төрийн өндөр албан тушаалтны 30 орчим хувь нь хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргаж ирүүлээд байна. Хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргах эцсийн хугацаа дуусахад хоёрхон долоо хоног үлдлээ.

Авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргаж, зарим байгууллагатай хамтарсан тусгай төлөвлөгөөний дагуу урьдчилан сэргийлэх ажил зохиож байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигачдын гэмт үйлдлийг баримтжуулах, улмаар тэднийг эрүүгийн хариуцлагад татаж мөрдөн шалгах шаардлагатай тохиолдолд хөрөнгө орлогын мэдүүлэг үнэн эсэхийг шалгах зэрэг цогц арга, хэрэгслээр авлигатай тэмцэх, түүнийг таслан зогсоох, нийгмийг цэвэршүүлэхэд чиглэсэн их ажил бодитой эхлэх болно.

Авлигын эсрэг эрч хүчтэй тэмцэл өрнүүлж, амжилтад хүрсэн улс орнуудын туршлагаас үзэхэд авлигатай тэмцэх гэдэг нь зөвхөн авлигачдыг барьж хорихыг урьтал болгохоос илүүтэйгээр авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтийн дотор хамгийн оновчтой арга хэлбэрээр зохион байгуулж, авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгэмд газар сайгүй төлөвшүүлэхэд л бүх анхаарлаа хандуулдаг байна.

Хөгжингүй зарим орны авлигатай тэмцэх хараат бус байгууллагууд авлигачдыг илрүүлэн цээрлүүлэхтэй нэг адил авлигыг үүсгэдэг шалтгааныг илрүүлж устгах талаарх хууль эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо, удирдлагын зохисгүй арга барилыг халж өөрчлөх, шударга ёс, ил тод байдлыг тогтоон хэвшүүлэх, ашиг сонирхлын зөрчлийг үгүй болгоход гол ажлаа чиглүүлж иржээ. Манай газар үүнийг иш үндэс болгон ажлаа чухамхүү үүнээс эхлэн явуулж байна. Энэ бол авлигатай тэмцэх газрын анхдагч бөгөөд байнгын зорилго байх болно.

Төр нь хуулийн дор байж, ард түмэн нь хууль дээдэлдэг, ардчилал хөгжсөн орнуудад хүнд суртал, чирэгдэл, авлига үүсгэдэг шалтгааныг хууль болон түүгээр тогтоосон дүрэм журам, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо, удирдлагын буруу арга барилаас үүдэлтэй хэмээн үзвэл тэдгээрийг илрүүлж өөрчлөн сайжруулахыг тэргүүн зэргийн зорилтоо болгож авлигачдыг барьж цагдахыг дараагийн ээлжинд тавьдаг байна. Энэхүү хоёр зорилтын байрыг сольж тавибаас хэчнээн олон авлигачныг илрүүлэн хорьж цагдан нийгмээс тусгаарлалаа ч авлигыг төрүүлж байгаа шалтгаан, нөхцлийг бүрдүүлэгч хууль эрх зүйн төгс бус орчин, зохицуулалт, бүтэц, зохион байгуулалтын буруу тогтолцоо, удирдлагын хоцрогдсон арга барил хэвээр байсан цагт авлигагүй нийгмийг төлөвшүүлэх тухай ойлголт хийсвэр болдог байна. Эл асуудлыг хоёр

талын хүчин чармайлтаар амжилттай шийдвэрлэхийн тулд авлигад өртөмтгий гэгддэг байгууллагууд, тэдгээрийн удирдлага манай газартай байнга нягт хамтран ажиллахаас өөр аргагүй болж байна гэсэн үг.

Хүнд суртал, чирэгдэл, авилга үүсгэхэд хүргэсэн хууль эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо, удирдлагын арга барилыг өөрчлөн сайжруулах арга замаар авлигагүй нийгмийг цогцлоох ажлын хувь заяа хууль тогтоогчид, гүйцэтгэх засаглалынхан, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгчид болон төр, захиргааны бусад байгууллагуудын эрх мэдэл бүхий удирдах албан тушаалтнууд авлигатай тэмцэх тууштай хүсэл зоригтой байгаа эсэхээс шууд шалтгаална.

Өнөөдрийн үндэсний бага хуралд тавьж хэлэлцүүлж байгаа илтгэлүүдээс үзэхэд төр, засгийн өндөр эрх мэдлийг хэрэгжүүлэгч албан тушаалтнууд манай оронд нүүрэлсэн авлигын эсрэг фронтод нэгдэцгээн тэмцэх чинхүү хүсэл эрмэлзэлтэй байгаа нь ажиглагдаж байна. Манай жирийн шударга иргэд, тэдний төлөөлөл болсон иргэний нийгмийнхэн, хэвлэл мэдээллийнхэн энэ фронтын тэргүүн эгнээнд аль хэдийнээ зогсоцгоосон. Эндээс дүгнэлт хийхэд Монгол оронд авлигагүй нийгмийн төлөөх сэтгэл зүй, зөв чиглэл бүрэлдэж байна гэж баттай хэлж болно.

Авлига үүсэхэд нөлөөлдөг тогтолцооны шинжтэй эдгээр шалтгаануудыг дан ганц авлигатай тэмцэх газраас олж илрүүлж, хуулинд заасан бүрэн эрхийнхээ дагуу шахаж шаардсанаар бүрэн засагдаж сайжирчихгүй.

Иймээс төр, захиргааны бүх шатны байгууллагын удирдах албан тушаалтнууд өөрсдөө туйлын шударга байж, нэгэнт гаргасан хууль, дүрэм, журмын чухамхүү аль нь үйлчлүүлэгчид хүнд суртал, чирэгдэл учруулж, авлига авч, өгөлцөхөд хүргэдгийг өөрсдөө олж илрүүлэн цаашид гаргах бүхий л шийдвэрээ албан тушаалтнууд хувийн явцуу эрх ашиг, сонирхолд үл захируулан нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн гаргаж байх нь авлигаас урьдчилан сэргийлэх арга замуудын нэг мөн.

Авлигатай тэмцэх газраас цаашид баримтлах бодлогын чанартай өөр нэг асуудал бол “авлигачид” гэж олон түмэнд байнга хардагдан шүүмжлэгддэг албан хаагчидтай авлигад өртөмтгий байгууллагууд, тэдгээрийн эрх баригчидтай авлига үүсгэдэг шалтгааныг арилгуулах асуудлаар тулж хамтран ажиллахыг эрхэм зорилгоо болгоно. Ялангуяа хамт олных нь дотроос авлигын хэрэг илэрсэн нөхцөлд тухайн

байгууллагын хүрээнд мөрдөгддөг хууль, дүрэм, журам, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо, арга барилд байж болзошгүй хүнд суртал, чирэгдэл, авлига үүсэхэд нөлөөлсөн хүчин зүйлүүдийг олж илрүүлэн арилгуулахын төлөө манай байгууллага тун идэвх зүтгэл гаргах болно. Ингэж ажиллахад удирдах нөхөд, албан тушаалтан хэн боловч дургүйцэхгүй, харин хамтран ажиллана байх гэж найдаж байна. Манай зүгээс төр, захиргааны байгууллагууд, олон нийтэд хандан авч хэрэгжүүлэх авлигаас урьдчилан сэргийлэх ажлын гол чиглэл нь итгүүлэн үнэмшүүлэхэд буюу авлига үүсгэж байгаа хүнд суртал, чирэгдлийг арилгуулах зорилго агуулсан зөвлөмж, шаардлага, санамж байхаас гадна лекц ярианы сэдэв, ухуулга сурталчилгааны зурагт хуудас, сургалтын хөтөлбөр, кино, үзүүлэн тануулах материал, аман ухуулгын зэрэг өгөөжтэй байж болох бүх арга хэлбэрүүдийг идэвхтэй ашиглах болно.

Бүх шатны сонгуулийн компани т ажил өрнөхөд нэр дэвшигчдэд болон нэр дэвшүүлэх эрхтэй улс төрийн хүчнүүд, тэдгээрийн удирдлагад ил, далдуур авилга өгч, эсхүл өөр бусад хэлбэрээр “үйлчилсэн” цөөнгүй хүмүүсийг эзэмшсэн мэргэжил, боловсрол мэдлэг, ажлын туршлага, ёс суртахууны төлөвшлийг огтхон ч харгалзахгүйгээр харьцангуй эрх мэдэл ихтэй албан тушаалд томилон хариу бэлэг болгосоор ирсэн гаж зуршил тогтсоныг арилгах цаг нэгэнт болсон. Үүнээс болж төрийн алба хүчгүйдэж, шударга бус, ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүсээр төр, засгийн бүх шатны албан тушаал дүүрч, зарим тохиолдолд төрд ажиллах ёс суртахууны эрхгүй хүмүүс ч ихээхэн эрх мэдэлтэй албан тушаалд томилогдон ажилладаг нь нууц биш ээ. Тийм хүмүүс төрийн албанд орсон хойноо шударга ажиллахын оронд авлигад өгсөн шархаа нөхөхийн тулд төрийн албанд мэргэшсэн шударга ажилтнуудыг шахаж цусгүй хэлмэгдүүлж, тэдний оронд өөрсдийн адил шударга бус тойрон хүрээлэгчдийг баг нэрийдлээр бүрдүүлж, дотооддоо ямар ч хяналтгүй “аалзны тор”-ыг нэхэж эхэлдэг.

Ер нь шударга бус бусармаг явдалтнууд хариуцлагаас нуугдаж хоргоддог газар нь төрийн сонгуульт албан тушаал, тэр тусмаа Монгол Улсын Их Хурлын гишүүний албан тушаал биш гэдгийг энэ хүндэт индэр дээрээс нийтэд хариуцлагатайгаар мэдэгдэж, Авлигатай тэмцэх газраас төрөө цэвэр байлгах, төрийн албыг хамгийн шударга хүмүүсээр бэхжүүлэх нийтлэг эрх ашгийг удирдлага болгон **СОНГУУЛИЙН**

АВЛИГАТАЙ тууштай тэмцэхэд бүх хүч, анхаарлаа чиглүүлэх болно гэдгээ энд онцлох нь зүйтэй хэмээн үзэж байна.

Сонгуулийн авлигаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох зорилгоор бүх шатны сонгуулийн болон улс төрийн намуудын тухай хууль тогтоомжуудыг эргэн харж боловсронгуй болгох, “сонгуулийн авлига”, “үндэсгүйгээр баяжих”, “төрийн албан хаагчдын хүнд суртал чирэгдүүлэлтээс иргэдэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх” тусгай заалтуудыг шаардлагатай бол холбогдох хуулиудад нэмж цаг алдалгүй тусгах боломжтой гэж үзэж байна.

Авлигын их, багын хэмжээ, авлига-хээл хахуулийн хэрэгт оролцогчдын гүйцэтгэсэн үүргийг харгалзаж хариуцлага тооцоход уян хатан эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжуудад цогцоор тусгасан нэмэлт, өөрчлөлт хийж авлигатай тэмцэх ажлын хууль зүйн орчинг улам боловсронгуй болгохыг цаашид анхаарлын төвд байнга байлгах болно.

Дээд, дунд, доод шатны ямар ч байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрмээр зохицуулагдахгүйгээр төрийн албыг хувийн явцуу эрх ашиг сонирхолтойгоо хутгаж, шударга бус ажиллахын үндсэн шалтгаан болдог ашиг сонирхлын зөрчлийг арилгахад чиглэсэн хуулийн төслийг санаачлан боловсруулан батлуулж төрийн албаны томилгоо хийх бүрийд иш үндэс болгож байх явдал чухал ач холбогдолтойг манай өнөөгийн улс орны дотоод нөхцөл байдал, ардчилал хөгжсөн, авлигатай тэмцэх ажилд амжилт олсон орнуудын туршлага бэлхнээ харуулж байна.

Авлигачдын хүлээсэнд орсон төрийн албыг цэвэршүүлэхийн тулд авлигад нэр холбогддог хүмүүсийг сонгууль болон албан тушаалд нэр дэвшүүлэх нь улс төрийн хүчнүүдийн нэр хүндэд халгаатайг тэдгээрийн удирдлагад хариуцлагатайгаар сануулж, нэгэнт нэр дэвшсэн тохиолдолд дахин сонгохгүй байхыг ард түмэндээ уриалж байна. Шударга сонгууль бол ардчилал хөгжсөн орнуудад авлигачдаас ял хариуцлага, шорон гяндангүйгээр ангижирдаг, авлигыг таслан зогсоодог сонгодог хэлбэр болдог юм. Иймд хамгийн үнэнч шударга хүмүүсийг олж сонгох явдал гэдгийг хэвлэл мэдээлийнхэн, иргэний нийгмийн төлөөллийнхэнд хандан хэлж, үүнийг өргөн олонд сайн сурталчилаарай гэж зориуд хүсмээр байна.

Авлигатай үнэн сэтгэлээсээ тэмцэцгээе, байгууллага, хамт олныхоо дотроос авлигачдыг төрүүлэхгүй байцгаая гэвэл хувь хүний ёс суртахууны эрхэм нандин чанар болох үнэнч шударга зан байдлыг гол шалгуур үзүүлэлт болгож, гагцхүү хэний ч нөлөөнд автагдахааргүй хамгийн шударга сайн ажилтнуудыг дэвшүүлдэг больё. Ингэж ажиллахгүйгээр, авлигад өртөмтгий байгууллагуудын удирдлагад төдийгүй тусгай зөвшөөрөл, лиценз, бүртгэл, шалгаруулалт хийдэг, хяналт тавьдаг, шийдвэр гаргадаг түвшингийн авлига авдаг гэж нэрлэгддэг албан тушаалд шударга бус, ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүсийг сонгууль бүрийн дараа сольж өрөөд байвал авлигатай тэмцэнэ, улс орноо хөгжүүлнэ гэж ярих нь утга учиргүй хэрэг болно. Энд нэг зүйлийг нэмж өгүүлэхэд төрийн үйлчилгээг иргэд, байгууллагад үзүүлдэг албан тушаалтуудад хамгийн шударга, нэр хүндтэй ажилтнуудыг сонгон авч, боломжтой нөхцөлд байнга сэлгэн ажиллуулж, хүнд суртал, чирэгдэл учруулалгүй, шударга сайн ажилласных нь төлөө тэднийг урамшуулан дэмжих нь авлигаас урьдчилан сэргийлэх шалгарсан сайн арга болно гэж бид үзэж байна.

Төрийн үйлчилгээ авч байгаа жирийн иргэд, хуулийн этгээдийг залхтал явуулж хүнд суртал, чирэгдэл учруулсаар буй хууль, дүрэм, журам, ёс зүйн дүрмүүдээ зориуд эргэн харж, Авлигын эсрэг хуульд заасны дагуу төрийн үйлчилгээг олон шат дамжлагагүй болгох, ажилтнууддаа албан үүргээ гүйцэтгэхдээ баримтлах ёс зүйн хэм хэмжээ, хийж болох, эс болох үйлдлүүдийг нарийн зааглаж боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэж байна.

Манай төрийн байгууллагууд дотор ёс зүйн дүрэмгүй атлаа ёс зүйдээ хяналт тавих чиг үүрэгтэй ёс зүйн дэд хороо гэсэн бүтцийн байгууллагатай цорын ганц гэж хэлж болох байгууллага бол Монгол Улсын Их Хурал билээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд төрийн байгууллагуудад үлгэр жишээ болохуйц ёс зүйн дүрэм боловсруулан баталж, түүнийгээ өөрсдөө чанд баримтлан манлайлж чадна гэж бодож байна. Манай нийгмийн бүх гишүүд цэнхэр дэлгэцийнхээ өмнө сууж та нөхдийг харах бүрийдээ ирээдүйн сайн сайхныг итгэлтэй төсөөлж, сэтгэлийн таашаал, хүндтэй хүмүүс байна гэж дүгнэх цаг жинхэнэ утгаар бүрдэх ёстой гэдэгт итгэл төгс байна. Ийм итгэл гагцхүү Авлигатай тэмцэх газрын шинэ хамт олны,

магадгүй төрөө дээдэлдэг манай бүх иргэдийн бодол сэтгэлийн гүнд байгаа их хүлээлт юм.

Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд ёс зүйгээрээ төрийн бүх албан хаагчдыг үлгэрлэн манлайлахдаа улстөрчдийн ёс суртахууны өндөр хариуцлагатай байж, ашиг сонирхлын зөрчилтэй тулгарвал өөрсдөө татгалзан зайлж чадах иргэний зоригтой, авлигад нэр холбогдож ёс зүйгээ зөрчсөн тохиолдолд хэнээр ч шаардуулахгүйгээр ухамсартайгаар огцордог ардчилал хөгжсөн орнуудын соёл, боловсролтой улстөрчдийн жишгийг дагах нь авлигаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой болно.

Авлигатай тэмцэх газраас бодлого болгон хэрэгжүүлэх дараагийн асуудал бол иргэд, байгууллагад төрийн үйлчилгээ авахад зайлшгүй шаардлагатай мэдээллүүдийг нээлттэй, ил тод болгоход оршино. Үүний тулд төрийн үйлчилгээ үзүүлэх тухай дагаж мөрддөг дүрэм, журмуудыг цөөрүүлэх, шат дамжлага, зэрэгцэж давхацсан үйл ажиллагааг үгүй болгох, бараа материал худалдан авах, тусгай зөвшөөрөл олгох, бүртгэл хийх, сонгон шалгаруулалт явуулах, буцалтгүй тусламж, зээлийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих ажлыг олон түмний оролцоотойгоор ил тод, үнэнхүү шударга болгох шаардлагатай байна. Түүнчлэн манай оронд авлигыг анх цэцэглүүлсэн өмч хувьчлалын луйвар, бүх төрлийн татвар, газрын алба, гааль, хуулийн байгууллагууд, эмнэлэг, сургуулийнхны авлига бидний анхаарлын гадна байх ёсгүй гэж үзэж байна. Ингэж ажиллах явдал татвар төлөгчид, жирийн иргэдээс авлигачдын халаас руу ордог асар их мөнгөний урсгалыг хаах, үнэ хөөрөгдөх, эцсийн байдлаар хэрэглээ болон үйлчилгээг хүртэгч иргэдэд учруулаад байгаа дарамтыг багасгах, авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсооход ихээхэн ач холбогдолтой юм.

Мэдээллийг нээлттэй, ил тод болгох ажлын хүрээнд, ялангуяа авлигад өртөмтгий үйлчилгээний байгууллагуудад нийтлэг дагаж мөрддөг хууль, дүрэм, журам, үйлчилгээний стандарт, албан хаагчдын ёс зүйн дүрэм, цагийн хуваарь, шаардлагатай мэдээлэл авахад бүрэн хариулт өгч чадах ажилтан, зайлшгүй бүрдүүлэн авчрах бичиг баримтууд, эцсийн хариу, шийдвэр гаргах, бүртгэл, шалгаруулалт болдог цаг хугацаа, холбоо барих утас, мэдээлэл, гомдол, санал өгөх арга замуудыг товч тодорхой нарийвчлан зааж үйлчлүүлэгчдийн нүдэнд харагдах газар

тавиулан хэвшүүлж, асуудлыг хүнд суртал, чирэгдэлгүй, шударгаар шийдэж байх нь уг асуудлыг авлигаар шийддэг гэж үздэг манай иргэдийн сэтгэлгээг өөрчлөх болно.

Төрийн үйлчилгээг үзүүлж буй хэн боловч дарга, жирийн албан хаагч гэж ялгаварлалгүйгээр овог нэр, албан тушаал, харилцах утасаа бичсэн нэрийн хуудсыг энгэртээ ил тод хадаж, иргэд, байгууллагад үйлчилж байхыг ажлын байран дээр байнга дагаж мөрдөх хэм хэмжээ болговол зохино.

Авлигатай тэмцэх газрыг үйлдвэрлэл эрхэлдэг нэгэн бизнесийн байгууллагатай зүйрлэвэл гол түүхий эд нь төрийн байгууллагын хүнд суртал, чирэгдэл, авлигачдын тухай “мэдээлэл” байх болно. Бид иргэдээс авах мэдээллийг бичгээр, амаар, утсаар 24 цагийн турш авч байхаар төлөвлөж байна. Үүнтэй зэрэгцүүлэн төрийн тусгай албаныхаа далдуур мэдээлэл цуглуулдагтай адил онцгой бүрэн эрхээ зөвхөн хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ. Шударга иргэдийн мэдээлэлд тулгуурлан ажил хэргээ зохион байгуулахдаа мэдээлэл бүрийн араас “чулуу хөөдөг нохой шиг үсчиж”, авлигач гэж дурьдсан хүн бүрийг хорьж цагдсан их хэлмэгдүүлэлт болгоно гэж болгоомжлох хэрэггүй. Гэхдээ мэдээлэл бүрд ихээхэн ач холбогдол өгч, хүнд суртлын гох дэгээ болсон хууль, дүрэм, журам болон бусдыг чирэгдүүлсэн шударга бус албан тушаалтнуудыг тэрхүү ажлын байрнаас нь өөрчлүүлэх, үнэнхүү авлигач мөн эсэхийг тогтоох зорилгоор үндэслэлтэй сэжиг бүхий этгээдүүдийг байнгын хяналтад байлгаж, гэмт үйлдлүүд нь гарцаагүй баримт нотолгоотой болсон этгээдийн эрхэнд халдаж, төрийн хуулийн дарангуйлалыг мэдрүүлж, тэднийг нийгмээс тусгаарлан төр, засгаа цэвэршүүлэхийг хичээн ажиллах болно.

Авлигачдын тухай мэдээ, мэдээллийг хүлээн авч шалгахдаа мэдээлэгчдээс заавал нэр, хаягаа өгөхийг шаардахын оронд хамгийн үнэн, аль болох баримт нотолгоотой байхыг урьтал болгон хүсэх болно.

Төрийн албыг авлига авах, хууль бусаар баяжих түшиц газар, арга, хэрэгслээ болгосон этгээдүүд, төрийн албан хаагчдын ёс зүйг уландаа гишиглэсэн хүнд сурталт түшмэдийн хаяг, нэр, баримт нотолгоо сайтай мэдээлийг Авлигатай тэмцэх газарт ирүүлсэн шударга иргэдээ авлигач, хүнд сурталтнуудын золиос болгохгүйн тулд тэдний хууль ёсны эрх ашиг, нэр төрийг тууштай хамгаалан ажиллана. Энэ бол авлигатай тэмцэх

газар өнө удаан оршин тогтнохын, эс оршин тогтнохын, чиг үүргээ амжилттай хэрэгжүүлж чадах эсэхийн гол баталгаа мөн гэж бид үзэж байна.

Манай байгууллагын чиг үүргийн дагуу хуулиар харъяалуулсан хэргүүдийн талаар үндэслэлтэй мэдээлэл ирүүлсэн шударга иргэд, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчдийг зөвхөн хамгаалаад зогсохгүй өгсөн мэдээлэл нь шүүхийн шатанд батлагдсан нөхцөлд урамшуулалын механизмыг бүрдүүлж үйлчлүүлэх болно.

Авлигатай тэмцэх газраас бодлогын чанартай баримтлах дараагийн нэг гол асуудал бол нийгмийн шударга ёсыг жинхэнэ утгаар бэхжүүлэх, хүнд суртал, чирэгдүүлэлт, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгын төлөө хоёргүй сэтгэл өвөрлөн ажилладаг иргэний нийгмийнхэн болон ард түмний дуу хоолойн чөлөөт индэр болсон хараат бус хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчидтэй дотно түншилж, гурвалсан холбоонд нэгдэн ажиллана.

Авлигатай тэмцэх газар иргэний нийгмийнхэн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллахдаа тэдний илрүүлэн олж нийгэмд дуулиан тарьдаг хүнд суртал, чирэгдэл, авлигын тухай мэдээлэлд ач холбогдол өгч, байнга анхаарал төвлөрүүлэхийн дээр шударга иргэдээс ирүүлсэн мэдээлэлийг шалгахад баримтлах дээр өгүүлсэн байр сууринаасаа хандаж ажиллана. Иргэний нийгмийн байгууллагынхны бүтээлч санаачлага, их нөөц бололцоог авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд зохистой ашиглахад Авлигын эсрэг хуулиар баталгаажуулж өгсөн Олон нийтийн зөвлөл холбогч гол гүүр болно гэж үзэж байна.

Цаашид манай байгууллагаас хүнд суртал, чирэгдэл, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг өргөн олон нийтэд хамгийн хүртээмжтэй арга, хэлбэрээр хүргэж, тайлбарлан таниулахад хэвлэл мэдээллийн хүчирхэг хэрэгсэл, тэдгээрийн сэтгүүлчид, иргэний нийгмийнхэн, бололцоотой бусад бүх байгууллагатай манай байгууллага, иргэдтэй манай байгууллага олон нийтийн зөвлөлөөрөө дамжуулан нягт хамтран ажиллахыг байнгын гол зорилгоо болгоно.

Манай байгууллагатай түншлэгч хэн боловч авлигачдын тухай мэдээлэл сонсоод үнэн, худлыг тогтооход цаг хугацаа, бусад олон хүчин зүйл нөлөөлөхийг харгалзалгүйгээр тухайн асуудалд сэтгэлийн хөдөлгөөнөөр хандаж, ташаа мэдээлэл тарааж, хэн хэнийхээ нэр хүндийг унагах, олон түмний сэтгэл зүйг төөрөгдүүлэхгүй байх ёстой.

Нийгмийн шударга ёсны тогтолцоо бүрдүүлэх тулгуур багануудад багтдаг хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааг зөв гольдролоор эхлүүлж, харилцан бие биедээ хүндэтгэлтэй хандаж, шаардлага гарсан үед нэг нь нөгөөгөө нөхөх байдлаар үр ашигтай хамтран ажиллаж чадвал манай эх оронд нүүрэлсэн авлигатай тэмцэхэд жинтэй хувь нэмэр оруулна гэдэгт би хувьдаа бат итгэлтэй байна.

Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, авлигын хэргийг мөрдөн шалгах чиглэлээр хууль, хяналтын байгууллагууд, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй зарим төрийн тусгай албадтай авлигын эсрэг хуулийн хүрээнд мэдээлэл солилцож, шаардлагатай асуудлаар санал бодол, хүч, хэрэгсэл зэрэг үгүй, дутуу бүхнээрээ харилцан бие биедээ тусалж хамтран ажиллахад Авлигатай тэмцэх газрын удирдлага ихээхэн анхаарал тавих болно.

Прокурор, шүүхийн байгууллагын бүх түвшингийн удирдлага авлигачдын хэргийг мөрдөн шалгах манай газрын үйл ажиллагаанд хяналт тавих, эцэслэн шийдвэрлэх ажлын хувь заяаг тухайн хэргийн этгээдүүд болон тэдний хань хамсаатнуудын нөлөөнд хэзээ ч үл автах ашиг сонирхлын зөрчилд ороогүй, хамгийн шударга, туршлагатай шалгарсан сайн ажилтнууддаа даатган хариуцуулахаас бидний хамтын ажиллагаа хүртээмжтэй байж зохих үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

Төрийн албан хаагчдын хүнд суртлын өмнө хүчин мөхөсдөж асуудлаа хууль журмын дагуу шийдвэрлүүлэхээс залхсан хувийн хэвшлийнхний авлига өгөх арга замыг сонгож, авлигачдыг улам өөгшүүлсээр ирсэн буруутай үйлдэл тэднийг өөрсдийг нь авлигын хэрэгт оролцогч болгох хуультайг ухаарч ажиллавал зохино. Авлигатай тэмцэх байгууллага, хяналт шалгалт тавих эрхтэй субъектүүд, хэвлэл мэдээллийнхэнд хандаж, авлига горьдсон хүнд сурталтнуудыг ил тодын дуранд тусгуулж, зохих хариуцлагыг заавал хүлээлгэдэг болгох хэрэгтэй

Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг хангахад ялангуяа төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж байгаа төрийн

байгууллагуудын анхаарлын төвд авлигатай тэмцэх ажлыг байлгахын тулд тэдгээрийг нэгдсэн нэг бодлого чиглэлээр хангах үндэсний хөтөлбөрийг гарган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг Авлигатай тэмцэх газар шинээр байгуулагдсан, холбогдох хууль тогтоомж өөрчлөгдсөн зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэж шинэчлэн батлах шаардлагатай байна. Гэхдээ энэхүү хөтөлбөрийг Засгийн газраас баталж хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй юм. Учир нь үйлчилгээг иргэдэд хүргэх төрийн үндсэн чиг үүргийг гүйцэтгэх засаглалын байгууллага, албан тушаалтнууд хэрэгжүүлж байгаа тул тэдгээрийг авлигаас ангид байлгаснаар иргэдийн төрд итгэх итгэлийг дээшлүүлэх ач холбогдолтой юм.

Төрийг төлөөлж иргэдтэй харилцаж байгаа төрийн албан хаагчийг авлигаас ангид байлгах талаар цогц арга хэмжээг энэхүү үндэсний хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх улмаар төрийн үйл ажиллагааны тогтолцоонд байгаа хүнд суртал, чирэгдэл, авлигыг арилгахын төлөө бид хамтын хүчээр тодорхой бодлого чиглэлтэйгээр хамтран ажиллавал богино хугацаанд амжилтад хүрч чадна.

Анхаарал тавьсан баярлалаа.